

НИЙГМИЙН ӨМНӨ ХАРИУЦЛАГАТАЙ СЭТГҮҮЛЗҮЙ БОЛ
ЁС ЗҮЙТЭЙ СЭТГҮҮЛЗҮЙ МӨН

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүл зүй, либерал үзэл баримтлал, "хязгааргүй" эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ёс зүйтэй сэтгүүл зүй.

Нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүлзүй хэмээх нэр томъёо ХХ зууны эхээр, цэвэр "либерал" үзэл баримтлалын зарим нэг тодорхойгүй, эргэлзээтэй асуудлыг нягтлах, мэдээллийн бодит үнэн байдлыг хангах, дуулиан шуугианаас татгалзах тухай нийгмийн шүүмж, тайлбар, мэтгэлцээний хүрээнд анх гарчээ. Энэ нь хүний эрх чөлөө бүр ямар нэг хариуцлага, үүргийг агуулж байдгийн адил хэвлэл мэдээлэл ч онцгой эрх эдэлж байдгийн хувьд нийгмийн өмнө хариуцлага хүлээж, өөрийн үүргээ гүйцэтгэж байж сая оршин тогтнох ёстой гэсэн онол ном юм. Гэхдээ энэхүү онол нь либертари үзэл баримтлалаас эх угшилаа авсан

гэдгийг хэлэх хэрэгтэй. Либертари онол нь өөртөө янз бүрийн үзэл санааг агуулдаг ба тэдгээрийн нэгээхэн хэсэг нь нийгмийн өмнө хариуцлагатай байх асуудлыг тодотгож байх жишээтэй. Ж.Милтоны үнэнийг олох дээдлэх тухай либертари үзлийн суурь ойлголт ч нийгмийн хариуцлагатай байх онолын үндэс билээ.

Нөгөө талаар хүн эрх чөлөөтэй байх ёстойн адил хийсэн үйлдэл, зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээж байх зан суртахууны хэм хэмжээг баримтлах үүрэгтэйг, энэ нь хүний мөн чанарын нэгээхэн зөрчил болохыг И.Кант анх олж харсан юм. Үнэхээр хүн төрөлх чанараараа бол эрх чөлөөтэй, бие даасан болох нь ойлгомжтой. Гэвч хүний үйл, хүсэл эрмэлзлэл бүр байгаль ертөнц, цаг үе магадгүй далдын хүчин зүйлээр нөхцөлдөх зайлшгүйн дунд оршдог. Түүнчлэн хүний ухамсар сэтгэхүйд нийгэм, эд хөрөнгө, эрх мэдэл гээд нөлөөлөх

гадаад хүчин зүйл бий. Тэхлээр хүн тэр, нийгэм ч тэр хүсэл эрмэлзлэл, эрхээ хязгаарлах, бусдынхтай зохицуулах, хүлцэн тэвчих гээд үүрэг хариуцлагаа ухамсарлах даган мөрдөх ёстой болно. Энд хүн өөрийн эрхээ бодит, үнэн хэмээн бусдад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд бусдынхыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн дүгнэлт гарч байна. Тиймээс сэтгүүлч нэгнээс сонин, телевиз, радио тэр бүү хэл, мэдээллийн тогтолцоо бүхэлдээ өөрийн эрх, нөлөөгөө бодит зүйл болгон тогтнуулахын үндэс нь нийгмийн, бусдын, хувь хүний хүртэл эрхийг дээдлэх ёстой, үүнд сэтгүүлзүйн хариуцлагын утга учир оршино гэсэн үг. Тэгээд ч "хүсэл зориг, эрх, зорилгын хамгийн сайн зарчим нь зөвхөн чинийх байхын зэрэгцээ мөн бүх нийтийн, хууль эрхзүйн зарчим байхаар биеэ авч явж, үйл хөдлөлөө тохируулж бай" гэсэн И.Кантын үгийг хариуцлагатай сэтгүүлзүйн мөрдлөг гэж үзэж байна.

Бас түүний "Чи өөрөөрөө болон бусад хүмүүсээр дамжуулан хүн төрөлхөнд зорилго гэж л хандаж бай, тэдэнд хэрэгсэл мэтээр хэзээ ч бүү ханд"¹ үгийг сэтгүүлзүйн хариуцлагын нотолгоо болгох хэрэгтэй биз ээ. Хөдөлмөрлөх чадвар ба эд баялаг арилжааны үнэ цэнэтэй, хурц ухаан амьд хийсвэрлэл, хөгжөөн цэнгээн нь сэтгэлзүйн үнэ цэнэтэй, хэлсэн үгэндээ үнэнч байж, зарчмыг хүндэтгэн дагах нь мөн чанарын үнэ цэнэтэй гэсэн мэргэдийн ухааныг

сэтгүүлзүйн хариуцлагын учир шалтгаан гэнэ.

Энд хэвлэл мэдээлэл ба ДОХ-ын бас хүний эрхийн асуудалд хамгийн их хэлцэгддэг нэгэн жишээг иш татмаар байна. "Үг" сонин эрхлэгч ДОХ-той хэмээн гүтгэгдэн нэгдүгээрт байгууллагын, хоёрдугаарт гэр бүлийн, гуравдугаарт нийгмийн хүчирхийлэл дор амь насаа алдсан нэгэн эмэгтэйн тухай худал мэдээллийн эх сурвалжаа нуун шоронд жил шахам хоригдсон түүхийг бид мэднэ. Мэдээллэх, эх сурвалжаа нуух нь сэтгүүлчийн эрх хэмээн тунхаглаж байсныг санаж байна. Улс төржилт, намуудын зөрчлийн золиос боллоо гэж мэдэгдэж бүр оны шилдэг хэмээн өргөмжлөгдөж шагналаа гардаж байсан дүр явдал телевизээр нийгэмд цацагдаж байсныг ч санаж байна. Бас би тэр хүнд багш болоод анхны хичээлээ зааж байснаа нуухгүй ээ. Энд сэтгүүлч эрхээ эдэлж харин бусдын зөвхөн түүнийг амьд байхад л оршдог өвчтэй болох төрөлх эрхийг хөсөрдүүлж, дараа нь бас нэр төр, өөрийнхөөрөө байх ариун хүсэл эрхийг нь гутаасан худал мэдээллийнхээ эх сурвалжийг нууж, улс төрийн намыг хувь хүний эрх ашгаас дээгүүрт үзэж дээр өгүүлснээр бол "хүнд хэрэгсэл төдийгөөр" хандсан юм. Сэтгүүлч өөрөө ч улс төрийн нам хүчин магадгүй хэн нэгний хэрэгсэл болжээ. ДОХ бол эдгэдэггүй болохоос өвчин бас өвчтэй болох нь хүний төрөлх эрх, тийм

байлаа ч нэр төртэй бусдын дунд амьдрах нь хүний бурхнаас заяасан халдашгүй хэн ч шүүж үл болох ариун нандин эрх юм. Харин сэтгүүлч үүнийг зөрчсөн тэгсэн хирнээ "мандан бадарсан". Ийм байж болохгүй ээ. Энд л нийгмийн хаиуцлагатай, ёс зүйтэй сэтгүүлзүйн утга учир оршиж байна.

Хэвлэл чөлөөтэй байх тухай онол нь Европын Сэргэн мандалтын эрин үеийн ертөнцийг үзэх үзлийн үр жимс юм. Тиймээс ч мөнхийн хөдөлгөөнт И.Ньютоны үл өөрчлөгдөгч байгалийн хууль, оюун ухаант хүсэл зорилгот хүмүүний төрөлх эрхийн тухай Ж.Локкийн философи, сонгодог эдийн засгийн

төрийн хязгаарлагдмал оролцоо, жам ёсны эрх чөлөө бүхий зах зээлийн өрсөлдөөний нөхцөлд хүн бүр хувийн эрх ашгаа даган амьдрах бололцоог олгосноор, өөрөө өөрийгөө зохицуулагч, цэцэглэн хөгжсөн аж ахуй үндэстний баялгийг бүтээх тухай сургаал, Жон Милтоны чөлөөт нээлттэй үзэл бодлын орчныг тэтгэх замаар үнэнийг олж болох санаа зэрэг либерал онолын эх үндэс, суурь байв.

«

Нийгмийн омню хариуцлагатай сэтгүүлзүйн онолоор бол төр засаг хэвлэлийн эрх чөлөөг хянаж хязгаарлах эрх үгүй төдийгүй, харин ч түүнийг хөгжүүлэхэд дэм тус болох ёстой. Төр засаг нь нийгмийг мэдээллээр хангах сэтгүүлзүйн үйл ажиллагааг дэмжих, тийм нээлттэй харилцааны орчныг бүрдүүлэх эрх зүйн баталгаа, эдийн засгийн боломж, чөлөөт мэдээллийн эсрэг аливаа үйлдлийн хязгаарлалт зэрэг бодлого, шийдвэрээр poloолох үүрэгтэй болно.

»

Харин ХХ зуун бол Эйнштейны харьцангуй онол, Ч.Дарвины хувьслын сургаал, Ж.Кейнсийн төрийн зохицуулалт бүхий эдийн засгийн номлолын зуун байлаа. Энэ тухай Ж.Йенсен бичихдээ "Чөлөөт хэвлэлийн уламжлалт философийн үзэл ойлголт эрчтэйгээр орчин үеийн сэтгэлгээний хувьсгалд нуран унаж байсан нь бүхнээс тодорхой байв. Ньютоны тогтвортой, туйлын үнэн байсан ертөнцийн хууль орчин үеийн физикийн харьцангуй, өөрчлөлт бүхий онолын сэтгэлгээнд зүгээр л эвдэрч орхив. Локкийн төрөлх эрхийн тухай номлол философийн төдийгүй, нийгмийн шинжлэх ухааны оргил санаа байхаа бо-

лив. Сонгодог эдийн засгийн чөлөөт үйлдвэрлэлийн онол ч орчин үеийн ихэнх эдийн засагчдын хувьд онцгой зүйл биш болов. Гэхдээ энэ бүхнээс илүү Ж.Милтоны "үнэнийг мэдэх" онол номлол итгэл үнэмшилтэй сонсогдохоо болилоо"² гэжээ.

Ийнхүү Ньютоны хууль, уламжлалт философийн үзэл номлол байр сууриа алдсанаар бие хүний эрх чөлөөнөөс илүү нийгэм, хамт нийтийн онол либерал

ертөнцөд хүч түргэн орж ирэв. Нийгмийн зөрчилт хоёр онол болох бие хүн ба хамт нийтийн тухай үзэл баримтлалын дунд хэвлэл мэдээллийн үүрэг, байр суурийг хэрхэн томъёолох нь түвэг бэрхшээлтэй асуудал болов. Мэдээж хамт нийтийн онол нь нийгмийг бие хүнээс илүү нэгдүгээрт үзэх болжээ. Гэхдээ хамт нийтийн онолын төгсгөл гаргалгаа нь харамсалтай нь коммунизм, фашизм байсан юм. Энэ бол нийгмийг дээдлэгч үзэл санааны туйлшрал, төөрөгдөл байлаа.

Тиймээс бие хүнийг дээдлэгч үзэл номлолын зарчимд тулгуурлан, хамт нийтийн зарим нэг "санааг" хүлээн авах нь юу юунаас илүү зөв болоод байв. Үүнийг ч нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүлзүйн онол агуулж чадсанаараа тоталитар хандлага уруу хэлбийх аюулыг тойрч гарсан юм.

Энэ нь хэт төвлөрөл, төрийн хяналт зохицуулалт нь дарангуйлал уруу зайлшгүй хөтлөхийг мэдэрсэн улс төрийн бодлогын төдийгүй, хэвлэл мэдээллийнхэн зөвхөн ашиг орлого бус нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарласны үр дүн байлаа. Түүнчлэн эдийн засгийн хүрээнд ч үйлдвэрлэгчид, худалдаачид хувийн эрх ашиг, сонирхлоо дээдэлснээр нийгмийн баялгийг бүтээдэг тухай үзэл, итгэл үнэмшлээ залруулж, нийгмийн өмнө тодорхой хариуцлага хүлээх болсноо зөвшөөрсөн юм.

Гэхдээ хэвлэлийнхний хувьд өв уламжлан ирсэн "хязгааргүй" эрх чөлөөгөө хариуцлагаар солих нь амаргүй байлаа. Бүр XIX зууны дунд үеэс эхэлсэн боловсролтой, өөрийн гэсэн амьдралын зарчимтай уншигчдад татагдах болсон сэтгүүлзүйн зарим төлөөлөгчид мэргэжлийн ёс зүйн мөрдлөгийг санаачилж байсан эхлэл, сургалтын тогтолцооны төлөвшил, Ж.Пулицерийн нийгмийн эрх ашгийг хамгаалан бизнесээ өргөжүүлсэн туршлага энэ бүхэн шинэчлэлтийн хөдөлгөгч хүч нь байлаа. Гэвч үйл явц тийм ч санаснаар, хурдан өрнөөгүй бөгөөд 1947 онд гарсан Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн комиссын илтгэлээр сая асуудал тодорхой болсон юм.

Нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүлзүйн онолоор бол төр засаг хэвлэлийн эрх чөлөөг хянаж хязгаарлах эрх үгүй төдийгүй, харин ч түүнийг хөгжүүлэхэд дэм тус болох ёстой. Төр засаг нь нийгмийг мэдээллээр хангах сэтгүүлзүйн үйл ажиллагааг дэмжиж, тийм нээлттэй харилцааны орчныг бүрдүүлэх эрх зүйн баталгаа, эдийн засгийн боломж, чөлөөт мэдээллийн эсрэг аливаа үйлдлийн хязгаарлалт зэрэг бодлого, шийдвэрээр нөлөөлөх үүрэгтэй болно. Гэхдээ энэ нь мэдээллийн үйл амьдралд шууд оролцоно, зохицуулна гэсэн үг биш бөгөөд ердөө л үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улс төрийн "золиос, өгөөш" болгохгүй байхад

тусална гэсэн үг юм. Тэгээд ч төр хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахгүй, түүнд шууд нөлөөлөхгүй байх нь ёс зүйн үүрэг, зайлшгүй мөрдлөг нь байдаг.

Нийгмийн өмнө хэвлэл мэдээлэл хариуцлага хүлээнэ гэдэг ч ёс суртахууны үүрэг, мөрдлөгийг баримтлана гэсэн үг. Либерал онолын үзэл бодлоо илэрхийлэх хүний төрөлх эрх нь ямар нэг үүрэг хариуцлагыг "агуулдаггүй" байв. Хүн чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлж, бусад нь ч чөлөөтэй сонсдог байсан гэсэн үг. Бас хүн, үзэл бодолтой байсан ч илэрхийлэхгүй байх, бусад нь сонсохгүй байх эрхтэй байлаа. Тиймээс ч төрөлх эрх нь үнэнийг олох, "нийгэмд ашигтай" байх гэсэн зарчимд үндэслэгдсэн шигээ хүмүүст ойлгогдож, бодит байдалд ч тийнхүү оршсоор иржээ. Харин нийгмийн хариуцлага бүхий хэвлэлийн онолын хувьд үзэл бодлоо илэрхийлэх нь ёс суртахууных нь үүрэг болж, итгэл үнэмшил, хүн чанарынх нь баримтлал, мөрдлөгийн зайлшгүй болон тодорхойлогддог. Үүнийг ч Хокинг "эрх чөлөө нь ёс суртахууны үүрэгтэй. Харин ёс суртахууны үүрэг нь өөрийн хувийн эрх ашгаасаа татгалздаггүй шиг, тийм чухал эрхэм үнэлэмж"³ хэмээн тэмдэглэжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ч хувь хүний төдийгүй, нийгмийн эрх ашиг хэмээн үздэг. Дээр өгүүлсэн Комиссын илтгэлд "Хэрвээ хүнд чухал

үзэл баримт байгаа бол түүнийгээ илэрхийлэх үүрэгтэй. Энэ бол түүний нийгмийн сайн сайхан болоод өөрийнхөө хүн чанарын өмнө хүлээж буй үүрэг болно. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх нь зайлшгүй үүрэг бөгөөд энэ нь нийгэм, түүнээс ч илүү зүйл тухайлбал үнэний өмнө хүлээх хариуцлага"⁴ хэмээн онцолжээ.

Нөгөөтэйгүүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний туйлын дээд эрх зориг тэр дундаа бусдын эрх ашгаас өөрийнхийг илүүд үзэх, нийгмийн үнэлэмж, дэг журмыг үл ойшоох "дарх" хэмээн ойлгож болохгүй гэдэг. Бурхнаас хүнд заяасан төрөлх хишиг болох эрх чөлөө хэмээн ойлгох нь төр засгийн дарангуйллыг яллах түүхэн үүргээ гүйцэтгээд нэгэнт өнгөрчээ. Тиймээс өнөөдөр эрх чөлөөний асуудлыг өөрөөр үзэх, эргэн харах нь зайлшгүй зүйл болоод байгаа билээ.

Ишлэл

№ Роберт Вольф. 2002. Философийн тухай. УБ., тал 61.

² Jensen J. 1950. Toward a Solution of the Problem of Freedom of the Press. N.-Y., p. 401.

³ Сиберт Ф., Шрамм У., Петерсон Т. 1998. Четыре теории прессы. М., с. 145.

⁴ Мөн зох., 147 дахь тал.